

**Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ
хийх эрх зүйн зохицуулалт: тулгамдаж буй асуудал,
шийдвэрлэх арга зам**

**Legal Regulation for Conducting Ex-Post Evaluation
of the Implementation Outcomes of Legislation:
Challenges and Solutions**

Равдандорж Хатансайхан

Хууль зүйн ухааны магистр (LL.M)

*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан*

Улаанбаатар хот, Монгол Улс

khatansaikhan@legalinstitute.mn

Сарантуяа Халиун

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс

ХХН-ийн хуульч, өмгөөлөгч

Улаанбаатар хот, Монгол Улс

sarantuyahaliun@gmail.com

© R.Khatansaikhan, S.Khaliun, 2026



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

2015 оныг хүртэлх хугацаанд Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж нь тодорхой төлөвлөгөө, тооцоо судалгаанд үндэслэхээс илүүтэйгээр тухайн цаг үеийнхээ нийгэм, эдийн засгийн шаардлагад нийцүүлэн боловсруулах хандлагатай байв. Үүнийг өөрчлөх үүднээс Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийг үнэлэх”-ээр заасан.

Уг хэрэгцээ, шаардлагад үндэслэж, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, зардлыг тооцох, төсөл болон хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Энэхүү өгүүлэлд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх эрх зүйн орчин болон эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол үнэлэхэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг судалж, түүнийг даван туулахад чиглэсэн тодорхой саналыг дэвшүүлэв.

[Түлхүүр үг]

Хууль тогтоомж, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, тулгамдаж буй асуудал, хууль зүйн үндэсний хүрээлэн, хүний нөөц, боловсон хүчин.

I. Оршил

Монгол Улсын хувьд 2001 онд Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг баталсан. Уг хуулийг батлах үндэслэл шаардлагыг “... хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулахдаа тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааг нарийн судалдаггүй, бусад хуультай хэрхэн уялдаж байгаа талаар тодорхой судалгаа, санхүүгийн тооцоо хийдэггүй зэргээс шалтгаалан нэг салбарын эрх ашгийг явцуу хамгаалсан, хуульд заасан шаардлага хангахгүй, үг хэллэг, найруулгын хувьд учир дутагдалтай хууль гарах нь цөөнгүй тохиолдож байна...”¹ гэжээ. Гэвч уг хуулиар зохицуулах энэхүү асуудлыг судлахаас илүүтэйгээр “...хууль санаачлагч хууль санаачлах эрхээ хэрэгжүүлж, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцаа...”-г зохицуулжээ.²

Улмаар 2015 онд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийг шинэчлэн найруулсан. Энэ нь одоогийн Хууль тогтоомжийн тухай хууль юм.³ Уг хуулийн төслийг боловсруулах үндэслэл шаардлагыг “...хууль боловсруулах ажлын чанар, ялангуяа санхүү, төсвийн үр нөлөөг урьдчилан тооцоолж, үр дагаврыг үнэлэх үйл ажиллагаа хангалтгүй буюу хуулийн шаардлага амьдралд тэр бүр хэрэгжихгүй байна. Үүнээс үүдэн нэгэнт батлагдсан хууль хэрэгжихээс өмнө түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зарим зүйл, заалтыг хүчингүй болгох тохиолдлууд гарч, улмаар хууль тогтоох ажлын үр нөлөөг бууруулж байна...” хэмээн тодорхойлжээ.⁴

Өөрөөр хэлбэл, Манай улсын хувьд 2001 оноос эхлэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх агуулгыг хөндөж эхэлсэн боловч 2015 оныг хүртэл хугацаанд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх эрх зүйн орчингүй байв. Харин 2015 оны Хууль тогтоомжийн тухай хуулиар хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх эрх зүйн орчныг бий болгож, одоог хүртэл даган мөрдөж байна.

Энэхүү өгүүллээр хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулж байгаа хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх эрх зүйн зохицуулалт, түүнд тулгамдаж буй асуудлыг хөндөх болно. Ингэхдээ хуулиар

¹ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн хувийн хэрэг, (Улаанбаатар, 2001), 8 дахь тал.

² Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль (2001), Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2001, №45.

³ Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015, №45, 2015 он

⁴ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, өмнөх эшлэл 1, 14 дэх тал.

хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үүргийг хуулиар хүлээсэн хууль зүйн үндэсний хүрээлэнгийн туршлага, арга зүй, практикт үндэслэсэн.

II. Хууль тогтоомжид хэрэгжилтийг үр дагаварт үнэлгээ хийх эрх зүйн зохицуулалт

Энэ хэсэгт хууль тогтоомжийн тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн хэрэгжилтийн үнэлэх хэрэгцээ, шаардлага, хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд, засгийн газраас баталсан хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал зэргийг нарийвчлан авч үзэх болно.

А. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал ба хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин зургаадугаар зүйлийн 1, 2 дахь заалтад үндэслэж⁵, 2015 оны Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.⁶ Мөн Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эрх чөлөөтэй Монгол хүн” гэсэн бүлэгт “Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ, шаардлага, хэрэгжилтийг үнэлдэг болно” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.⁷

Өөрөөр хэлбэл, Манай Улсад 2015 оноос эхлэн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн. Ингэснээр хууль тогтоомжийн чанар, үндэслэл сайжирч, улмаар Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөө дээшилнэ гэж тухайн үеийн хууль тогтоогчид үзсэн.⁸

Энэ нь зөвхөн хуулийн төслийн үзэл баримтлалд дурдагдсан асуудал биш бөгөөд Монгол Улсын Их Хурлын хууль зүйн байнгын

⁵ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №1, 1992 он

⁶ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн хувийн хэрэг, (Улаанбаатар, 2015), 13 дахь тал.

⁷ Монгол Улсын Их Хурал, 2012 оны 37 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, (Улаанбаатар, 2012.) <https://legalinfo.mn/mn/detail?lawId=205591&showType=1> (сүүлд үзсэн: 2026.03.13).

⁸ Мөн тэнд.

хорооны 2015 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр /Мягмар гараг/-ийн дэлгэрэнгүй тэмдэглэлд Хууль зүйн сайд Д.Дорлигжав "...тус хуулиар хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд хууль тогтоомжийн чанарыг сайжруулах, хууль тогтоомж хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх зэрэг эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой..." гэж⁹ мөн "...хууль гарах болсон гол шалтгаан бол бараг л бүгдээрээ мэднэ дээ. Хуулийг тохиолдлоор гэнэт баталдаг, гэнэт санаачилдаг, үр дагаврыг тооцдоггүй, тооцоо судалгаа байдаггүй, хэрэгжих боломж нөхцөлийг судалдаггүй ийм байдлаар гарсан хуулиуд хэрэгжихэд бэрхшээл учруулдаг, ойлгомжгүй нэр томъёо байж байдаг гэх мэтээр. Сүүлийн үед тавигдаж байгаа шаардлага бол хуулийг боловсруулах, санал авахад олон нийтийн оролцоо санаа бодлыг тусгах шаардлага байна гэж ингэж үзэж байгаа. Хамгийн сүүлд хуулийн хэрэгжилтэд үнэлэлт өгөх ийм зүйлийг хуульд тусгаж байгаагаар гол шинэлэг зүйлүүд гэж хэлж болохоор байна..."¹⁰ зэргээр байр сууриа илэрхийлжээ.

Ийнхүү 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан¹¹, 2015 оны хаврын ээлжит чуулганы төрийн байгуулалтын байнгын хорооны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан¹², 2015 оны хаврын ээлжит чуулганы хууль зүйн байнгын хорооны 05 дугаар сарны 20-ны өдрийн хуралдаан¹³, 2015 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар¹⁴ тус тус хэлэлцэн одоогийн Хууль тогтоомжийн тухай хуулийг баталжээ.

Дүгнэн үзвэл, Манай улсын хувьд 2001 оноос эхлэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хэрэгцээ, шаардлагыг хуульчлах асуудлыг хөндөж, улмаар 2015 оны Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төсөлд анх удаа хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зохицуулалтыг тусгасан. Үүнийг хуулийн төсөл

⁹ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын 2015 оны Хууль зүйн байнгын хорооны дэлгэрэнгүй тэмдэглэл, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн хувийн хэрэг, Улаанбаатар, 2015.01.27, 63 дахь тал.

¹⁰ Мөн тэнд, 69 дэх тал.

¹¹ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл, 2015.01.30, (Улаанбаатар, 2015), 80 дахь тал.

¹² Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны тэмдэглэл, 2015.04.22, (Улаанбаатар, 2015), 120 дахь тал.

¹³ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дэлгэрэнгүй тэмдэглэл, 2015.05.20, (Улаанбаатар, 2015), 161 дэх тал.

¹⁴ Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, 2015.05.21, (Улаанбаатар, 2015), 199 дэх тал.

боловсруулагчийн зүгээс хуулийн хэрэгжилтэд үнэлэлт өгөх эрх зүйн орчныг шинээр буй дэвшилттэй хэмээн онцолж байв.

Б. Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх эрх зүйн зохицуулалт ба зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтүүд

Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 8 дугаар зүйлийн 8.1.1, 12 дугаар зүйлийн 12.1.6, 14 дүгээр зүйлийн 14.1, 15 дугаар зүйлийн 15.10, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.4, 21 дүгээр зүйлийн 21.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 40 дүгээр зүйлийн 40.1.2, 41 дүгээр зүйлийн 41.3.3, 49 дүгээр зүйлийн 49.3, 49.4, 49.6, 51 дүгээр зүйл 51.2, 51.3, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтад хэрэгжилтийн үр дагаварт хамаарах эрх зүйн зохицуулалтыг тусгажээ.

Эдгээр зохицуулалтыг нэгтгэн үзвэл, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах анхдагч үе шат бөгөөд хууль санаачлагч хуулийн тогтоомжийн төсөл боловсруулахын өмнө шинээр хууль боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, эсхүл тухайн харилцааг зохицуулж буй хуулийн тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх шаардлагатай. Энэхүү судалгааны дүгнэлтэд үндэслэж Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-8.1.9-д заасан ажлууд хийгддэг.¹⁵ Харин Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг хуульчлаагүй бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д аргачлал баталж, мөрдүүлэх эрхийг Засгийн газарт олгосон. /Үүнийг дараагийн бүлгээр хөндөх болно/

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 27-ний өдрийг хүртэл хугацаанд 13 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Эдгээр 13 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт /2017.05.12, 2023.05.04, 2024.05.16, 2025.06.27/ нь зарчмын шинжтэй, үлдсэн 9 удаагийн нэмэлт өөрчлөлт /2016.02.04, 2017.04.14, 2018.06.29, 2020.04.09, 2020.05.13, 2022.11.11, 2023.05.04, 2023.07.07, 2024.01.12./ нь хууль тогтоомжийг дагаж орсон өөрчлөлтүүд байна.¹⁶

Зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтийн агуулгад хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх асуудлыг хэрхэн тусгасныг харьцуулбал. Хууль тогтоомжийн тухай хуулийн 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хугацааг тодорхойлсон буюу 51 дүгээр зүйлийн 51.3 хэсгийг нэмж,

¹⁵ Хууль тогтоомжийн тухай хууль (2015), Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015, №25.

¹⁶ Мөн тэнд

Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг хамт ирүүлэх зохицуулалтыг бий болгосон.¹⁷

Харин тус хуулийн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар анхдагч хууль болон шинэчилсэн найруулга гаргах, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх байгууллагыг хуульчлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг хэлэлцэх зэрэг эрх зүйн хэм хэмжээг шинээр бий болгосон.¹⁸ Ингэснээр манай улсад анх удаа хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх эрхтэй байгууллагыг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн захиргааны төв байгууллага болон Хууль зүйн үндэсний хүрээлэн байхаар тодорхойлсон бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хувьд эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол үнэлэхийг хуульчилсан.

Хууль тогтоомжийн тухай хуульд зарчмын шинжтэй дараагийн өөрчлөлтийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан. Уг нэмэлт, өөрчлөлтөөр Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэлд анхаарч, Улсын Их Хурлын Тамгын Газар хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хянах шаардлагад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгаанд үндэслэн эсэхийг хамруулсан.¹⁹ Үүний үр дүнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний дараагаар хуулийн төслийг боловсруулах, судалгааны дүгнэлт, зөвлөмжид тулгуурлах чиглэлд анхаарах хандлага нэмэгдсэн.

Сүүлийн буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг хийх байгууллагатай холбоотой зохицуулалтыг нарийвчлах, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулах зэрэг өөрчлөлтийг бий болгожээ.²⁰ Энэ нь хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээний тайланг нийтэд нээлттэй болгох, иргэд олон нийтийн зүгээс судалгааны

¹⁷ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2017.05.12) <https://legalinfo.mn>.

¹⁸ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2023.05.04), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759308715161&showType=1>.

¹⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, (2024.05.16), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140673671341&showType=1> (сүүлд үзсэн: 2026.03.13).

²⁰ Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, (2025.06.27), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17432175037602&showType=1> (сүүлд үзсэн: 2026.03.13).

тайлантай танилцах хүрээнд чухал ач холбогдолтой зохицуулалт болсон. Учир нь legalinfo.mn-д хууль болон түүнтэй холбоотой хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг байршуулснаар тус вэбсайт нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан болоход нэг алхам ойртох юм.

Дүгнэн үзвэл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 2017 оны 05 дугаар сарын 12, 2023 оны 05 дугаар сарын 04, 2024 оны 05 дугаар сарын 16, 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтүүд нь тус хуулийн үзэл баримтлалд хамаарах суурь шинжтэй өөрчлөлтүүд юм. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ агуулгыг хөндсөн бөгөөд 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг хамт ирүүлэх зохицуулалтыг бий болгосон. Харин 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар хуулийн төсөл боловсруулах, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх байгууллагыг тодорхойлсон бол 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын Тамгын Газар хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хянах шаардлагад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байх шаардлагыг хамруулжээ. Сүүлийн буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулах өөрчлөлтийг тус тус оруулжээ.

В.Засгийн газраас баталсан хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын тухайд

Өмнөх хэсэгт дурдсанчлан Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг хуульчлаагүй бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д аргачлал баталж, мөрдүүлэх эрхийг Засгийн газарт олгосон.²¹ Засгийн газрын зүгээс энэхүү эрхийн хүрээнд 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар «Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал»-ыг, 2 дугаар хавсралтаар “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал»-ыг 3 дугаар хавсралтаар “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал»-ыг, 4 дүгээр хавсралтаар “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал» 6 дугаар хавсралтаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал»-ыг тус тус баталсан.²²

²¹ ХТГХ (2015)-ийн 12 дугаар зүйл 12.1.1-12.1.6.

²² Монгол Улсын Засгийн газрын 59 дүгээр тогтоол, Аргачлал батлах тухай (2016),

Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн тухай хуульд заасан хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар нарийвчлан заасан бөгөөд хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээ нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн 3 үе шатны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж байна.²³

Уг аргачлал батлагдахаас өмнө Хууль зүй, дотоод хэргийн яамнаас холбогдох аргачлалыг ашиглаж байсан. Тодруулбал, тус яамны зүгээс Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран 2008 оноос хэрэгжүүлж байгаа “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслийн хүрээнд хууль, хуулийн төслийн үр нөлөөг тандан судлах, үнэлгээ хийх үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор онол практикийн цуврал сургалтуудыг зохион байгуулж ирсэн. Үүний үр дүнд холбогдох аргачлалуудыг боловсруулан, батлуулж 2009 оноос хойш яамны хэмжээнд мөрдөн ажиллаж ирсэн.²⁴ Энэ ч утгаараа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалтай холбоотой гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төсөл хамтран 2016 онд хэвлэсэн.²⁵ Энэхүү бүтээл нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг агуулга, зорилгыг энгийн ойлгомжтой байдлаар нарийвчлан гарын авлага болгосон. Энэхүү гарын авлагын 300-329 дэх талд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал» буюу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг хялбаржуулан тайлбарласан.²⁶ Ингэснээр Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага нь Засгийн газрын 59 дүгээр тогтоолыг ойлгох, хэрэглэх гол эх сурвалж болдог.

Түүнчлэн, нэг талаас Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан зарчмын шинжтэй өөрчлөлтийн агуулга Засгийн газрын тогтоолоор

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11993> .

²³ Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хавсралт, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал (2016), <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338>.

²⁴ Хууль зүй, дотоод хэргийн яам; Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Хууль тогтоомжийн тухай хууль: аргачлал, гарын авлага (Улаанбаатар, 2016), 4 дэх тал.

²⁵ Мөн тэнд

²⁶ Хууль зүй, дотоод хэргийн яам, өмнөх эшлэл 24, 300-329 дэх тал.

батлагдсан аргачлалд тусгагдаагүй. Нөгөө талаас хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг 2016 оноос хойш тасралтгүй 10 гаруй жил ашиглаж байгаа бөгөөд түүнийг үнэлэх шаардлага тулгарч байна.

Үүнд, үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/48 дугаар тушаалаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг шинэчлэн боловсруулах дэд ажлын хэсгийг байгуулсан.²⁷

Дүгнэн үзвэл, Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг батлах эрхийг Засгийн газарт олгосон. Засгийн газрын зүгээс 2016 оны 59 дүгээр тогтоол болон түүний хавсралтаар хууль тогтоомжийн судалгааны аргачлалыг баталсан. Эдгээр аргачлалыг ойлгож хэрэглэхэд Хууль зүй, дотоод хэргийн яам болон Германы Олон Улсын Хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ээс хамтран гаргасан “Хууль тогтоомжийн тухай хууль аргачлал, гарын авлага” чухал нөлөө үзүүлдэг. Цаашид энэхүү аргачлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн зарчмын шинжтэй өөрчлөлтийг оруулах болон аргачлалыг ашиглахад эрдэмтэн судлаачдын санал, дүгнэлтэд үндэслэн сайжруулах шаардлага үүссэн.

III. Хууль тогтоомжид хэрэгжилтийг үр дагаварт үнэлгээ хийхэд тулгамдаж буй асуудал

Энэ хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд тулгамдаж буй асуудлыг тухайлан хөндөх болно.

А. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх боловсон хүчнийг бэлтгэх тухайд

2015 оны Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх эрх зүйн орчныг тодорхой болгосон. Ийнхүү эрх зүйн орчныг бий болгохоос өмнө буюу 2009 оноос хойш яамны хэмжээнд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж байв.²⁸ Улмаар 2013 оны үед Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран хууль тогтоомжийн судалгааны боловсон хүчин бэлтгэх сургалтыг зохион байгуулж 25 боловсон хүчнийг бэлтгэсэн. Уг сургалтыг ХБНГУ-ын Доод Саксон мужийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам болон Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга асан, хатагтай Фрийдерике Витте заасан. Гэвч үүнээс хойш 10 гаруй жилийн хугацаанд энэ чиглэлийн

²⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайд, 2026, А/48 дугаар тушаал, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг шинэчлэн боловсруулах дэд ажлын хэсэг байгуулах тухай.

²⁸ Хууль зүй, дотоод хэргийн яам, өмнөх эшлэл 24, 4 дэх тал.

судлаач, боловсон хүчнийг бэлтгэх ажил зогсонги байдалд орж, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлэх чиглэлийн туршлагатай хүний нөөцийн дутагдал үүссэн.

Энэхүү хүндрэлийг даван туулах зорилгоор 2024 оны 7 сарын 22-ны өдрөөс 7 сарын 26-ны өдрийн хооронд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн санаачилгаар Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсад хоёр дахь удаагаа “Хууль тогтоомжийн судалгааны аргачлалын сургагч багш бэлтгэх сургалт”-ыг зохион байгуулсан.²⁹ Уг сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Эрчим хүчний зохицуулах хороо, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургуулийн нийт 31 хууль зүйн салбарын судлаач, багш, мэргэжилтнүүд хамрагдсан. Сургалтыг ХБНГУ-ын Доод Саксон мужийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам болон Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга асан, хатагтай Фрийдерике Витте багш дахин зааснаараа онцлог байв.³⁰

Уг сургалт нь нэг талаас хууль тогтоомжийн судалгаагаар мэргэшсэн боловсон хүчний хомсдолыг арилгах, нөгөө талаас цаашид сургалтыг тогтмол зохион байгуулах сургагч багшийг бэлтгэх зорилгыг агуулж байв. Үүнээс хойших сүүлийн хоёр жилийн хугацаанд хууль тогтоомжийн судалгаагаар мэргэжсэн боловсон хүчнийг бэлтгэх сургалтыг зохион байгуулах чиглэлд анхаарч байна. Тодруулбал, МУИС-ийн Улс Төр Судлал, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуулиас зохион байгуулсан “Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл” зэргийн бус сургалтын хөтөлбөрт³¹ тодорхой хэмжээнд багтсан. Харин, 2026 он гарсаар Монголын Хуульчдын холбоо, Швейцарын хөгжлийн агентлагийн “Парламентын институтийг бэхжүүлэх нь” төсөл, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, МУИС-ийн Герман, Европын эрх зүйн төв зэрэг байгууллагуудтай хоёр удаа зохион байгуулсан бөгөөд сургалтын агуулгад хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал багтаж байна.³²

²⁹ “Хууль тогтоомжийн судалгааны аргачлалын сургагч багш бэлтгэх сургалт” эхэллээ, (2024), <https://nli.gov.mn/хтс-аргачлал/>, (Сүүлд үзсэн: 2026.03.13).

³⁰ Мөн тэнд

³¹ “Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл” зэргийн бус сургалтын гэрчилгээ гардуулаа, (2026), <https://news.num.edu.mn/?p=113410>, (Сүүлд үзсэн: 2026.03.13)

³² “Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт эхэллээ”, (2026), <https://www.mglbar.mn/a/5466>, (Сүүлд үзсэн: 2026.03.13); “Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт” хоёр дахь өдрөө үргэлжилж байна, (2026), <https://www.parliament.mn/nn/76791/>, (Сүүлд үзсэн: 2026.03.13).

Мөн, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.4³³, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийн 1.6 дугаар зүйлийн 3-т “Хуульч нь мэргэжлийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангана” гэж заасан.³⁴ Эдгээр сургалт нь танхим болон цахим, вебинар, практик гэсэн хэд хэдэн төрөлтэй төдийгүй Монголын хуульчдын холбооны цахим хуудсаар дамжуулах хамрагдах боломжтой. Гэвч Монголын хуульчдын холбооноос зохион байгуулж буй сургалтад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхтэй холбоотой сургалт байхгүй..

Түүнчлэн, Монгол Улсын Их Сургуулийн хууль зүйн сургуулийн эрх зүйн үндсэн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхтэй холбоотой хичээлийн хөтөлбөр багтаагүй бөгөөд сонгох судлах Хууль зүйн техник хичээлийн хөтөлбөрт товч агуулгаар хамаардаг.³⁵

Дээрхээс дүгнэн үзвэл, Манай Улсын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх боловсон хүчин, түүнийг бэлтгэх явдал нь практикт тулгамдаж буй томоохон сорилт мөн бөгөөд цаашид хууль тогтоомжийн судалгаагаар мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх асуудал чухлаар хөндөгдөж байна. Учир нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 2023 оны өөрчлөлтөөр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд тулгуурлахыг шаардаж байна. Иймд, хууль тогтоомжийн судалгаа, ялангуяа хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх чиглэлийн дагнасан сургалтыг эрх зүйн хичээлийн хөтөлбөрт оруулах, төрийн албан хаагч болон хуульч нарыг бэлтгэх чиглэлийн сургалтыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага бий болсон. Энэхүү сургалтыг тогтмол зохион байгуулах нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийж буй үнэлгээний арга зүй, чанарыг дээшлүүлэх, мэргэшсэн хүний нөөцийн дутагдлыг

³³ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012, №14, 2012

³⁴ Монголын Хуульчдын холбоо, Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, УБ, 2013, <https://www.mglbar.mn/resource/mglbar/File/2023/03/07/h02bixdnbxe3yoo7/%D0%A5%D1%83%D1%83%D0%BB%D1%8C%D1%87%D0%B8%D0%B9%D0%BD%20%D0%BC%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D0%B6%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D2%AF%D0%B9%D0%B0%D0%B0%D0%B6%D0%B8%D0%BB%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD%D0%B4%20%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82%D0%BB%D0%B0%D1%85%20%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC.pdf> (сүүлд үзсэн: 2026.03.13).

³⁵ Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль, Үндсэн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө, (Улаанбаатар, 2016,) <https://law.num.edu.mn/u/26/50/146> (сүүлд үзсэн: 2026.03.13).

арилгах ач холбогдолтой.

Б. Үнэлгээнд шаардагдах хугацааны зохицуулалтыг бий болгох

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3.”Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж хуульчилсан.³⁶ Уг эрх зүйн зохицуулалт нь хуулийн тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хугацааг тогтоосон зохицуулалт боловч хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах хугацааг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт байхгүй.

Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах хугацаа харилцан адилгүй байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7.1-д заасан эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт жил бүр үнэлгээ хийдэг. Ингэхдээ материаллаг болон процессын эрх зүйгээр ялган жилд нийт найман хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийдэг бөгөөд хагас жилд дөрвөн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийдэг.³⁷

Харин Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн цаг үеийн шинжтэй хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх хугацаа харилцан адилгүй. Жишээлбэл, 2025 оны 4 дүгээр улиралд Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар 8 хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн.³⁸ Ийнхүү хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хугацаа бага байх нь хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны чанар болон судлаачийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Иймд, Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах хугацааг тодорхойлох нь тус судалгааны чанарт эергээр нөлөөлөх боломжтой. Энэ нь зөвхөн хууль зүйн үндэсний хүрээлэнгийн асуудал биш бөгөөд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг захиалгын үндсэн дээр хэрэгжүүлж буй байгууллагын хувьд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хугацааг эртнээс төлөвлөх боломжийг бүрдүүлнэ.

³⁶ Хууль тогтоомжийн тухай хууль(2015)-ийн 51 дүгээр зүйл 51.3 , Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015, №25.

³⁷ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөө”, (2025), <https://nli.gov.mn/%D1%85%D1%83%D1%83%D0%BB%D1%8C-%D0%B7%D2%AF%D0%B9%D0%BD-%D2%AF%D0%BD%D0%B4%D1%8D%D1%81%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%85%D2%AF%D1%80%D1%8D%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BD%D0%B3%D0%B8%D0%B9%D0%BD-2025-%D0%BE%D0%BD-16/> (Сүүлд үзсэн: 2026.03.13).

³⁸ Мөн тэнд, 10 дахь тал

Г. Төрийн байгууллагын мэдээллийн уялдаа холбооны тухайд

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ чанар нь тухай хуулийг хэрэгжүүлсэн тайлан, дүн мэдээнээс шууд хамаардаг. Манай Улсын хувьд хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан мэдээний уялдаагүй, зөрүүтэй болон хаалттай байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт сөргөөр нөлөөлж байна.

Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын зүгээс өөрсдийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх, тайлан дүн мэдээг судалгааны эргэлтэд ашиглах байдлаар байршуулах, нээлттэй болгох тогтмол, шинэчлэх хүрээнд анхаарах шаардлагатай. Учир нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт шаардлагатай сүүлийн үеийн мэдээллийг холбогдох байгууллагаас албан бичгээр гаргуулахад хамгийн бага ажлын 7-14 хоног болон түүнээс дээш хугацаа шаарддаг. Энэ нь төрийн байгууллагын мэдээллийн уялдаа холбоог хангасан, нэгдсэн судалгааны санг бий болгохыг шаардаж байна.

Хэдийгээр үндэсний судалгааны нэгдсэн платформ болох “sudalгаа.gov.mn” төрийн байгууллагын мэдээллийн уялдаа холбоог хангах чиглэлд дэвшил гаргасан.³⁹ Гэвч төрийн бүхий л байгууллагын дата, мэдээг оруулах, цаг тухайд нь шинэчлэх шаардлагатай тулгарч байна. Мөн төрийн байгууллагын мэдээллийн уялдаа холбооны асуудал нь төрийн боловсон хүчний туршлага, мэдлэгтэй хамааралтай байдаг бөгөөд төрийн байгууллагын мэдээллийг залгамж чанар сул байгааг дурдах нь зүйтэй.

Д. Хууль боловсруулах үе шатанд тулгамдаж буй асуудал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-8.1.9-д хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатыг хуульчилсан.⁴⁰ Тодруулбал, дээрх хуулийн заалтын дагуу юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ёстой. Үүний дараагаар хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, баталдаг.⁴¹ Харин практикт энэхүү үе шатны дараалал алдах тохиолдол цөөнгүй. Учир нь хуулийн төслийн боловсруулсны дараагаар тэрхүү төсөлд нийцүүлэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хандлага давамгайлдаг. Энэ нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ач холбогдлыг бууруулах

³⁹ Үндэсний судалгааны нэгдсэн платформ, <https://sudalгаа.gov.mn/> (Сүүлд үзсэн: 2026.03.13).

⁴⁰ Хууль тогтоомжийн тухай хууль (2015)-ийн 8 дугаар зүйл, 8.1, Төрийн мэдээллийн эмхэтгэл: 2015, №25.

⁴¹ Хууль тогтоомжийн тухай хууль (2015)-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үзнэ үү, Төрийн мэдээллийн эмхэтгэл: 2015, №25.

эрсдэлтэй бөгөөд хуулиас гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг буруу илрүүлэх сул талтай. Цаашлаад тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг зөв тогтооход саад учруулж байна. Нөгөө талаас хуулийн төслийг боловсруулсны дараагаар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нь Хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчсөн буруу практикт юм.

Иймд, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-8.1.9-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатыг баримтлаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тогтолцоог бий болгох замаар хуулийн төсөл боловсруулсны дараа хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж буй байдлыг засах нь шаардлагатай.

IV. Дүгнэлт

Монгол Улсад хууль тогтоомжийг шинээр боловсруулах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулахын өмнө дараах үнэлгээг хийхийг шаарддаг. Үүнд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлэх” зэрэг хамаардаг. Эдгээр үнэлгээнээс хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг практикт өргөнөөр ашигладаг.

Энэхүү өгүүллээр хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ аргачлалын зорилго, үзэл баримтлал, хэрэгцээ, шаардлага, хууль тогтоомжийн тухай хуулийн зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлт болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг судлан дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Манай улсын хувьд 2001 оноос эхлэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хэрэгцээ, шаардлагыг хуульчлах асуудлыг хөндөж, улмаар 2015 оны Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зохицуулалтыг хуульчилсан. Ингэснээр хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, түүнд гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

2. Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан зарчмын шинжтэй дөрвөн удаагийн /2017.05.12, 2023.05.04, 2024.05.16, 2025.06.27/ нэмэлт, өөрчлөлт нь хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зохицуулалтыг сайжруулсан. Эдгээрт, Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг хамт ирүүлэх, хэрэгжилтийн үр дагаварт

үнэлгээ хийх байгууллагыг тодорхойлох, Улсын Их Хурлын Тамгын Газар хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хянах шаардлагад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааг хамруулах, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулах эрх зүйн зохицуулалтууд хамаарна.

3. Хууль тогтоомжийн тухай хуулиар Засгийн газарт хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг батлах эрхийг олгосон бөгөөд Засгийн газрын зүгээс 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг баталсан. Цаашид энэхүү аргачлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн зарчмын шинжтэй өөрчлөлттэй нийцүүлэх болон аргачлалын хэрэгжилтийг үнэлэх шаардлага үүссэн.

4. Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд дараах асуудал тулгарч байна.

4.1. Манай Улсын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх боловсон хүчин, түүнийг бэлтгэх явдал нь практикт тулгамдаж буй томоохон сорилт болсон. Иймд, цаашид хууль тогтоомжийн судалгаагаар мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх асуудал чухлаар хөндөгдөж байна. Учир нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 2023 оны өөрчлөлтөөр хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд тулгуурлахыг шаардаж байна.

4.2. Хуулийн тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах хугацааг хуульчлаагүй. Энэ нь хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд харилцан адилгүй хугацааг баримтлах үндсэн нөхцөл болдог. Практик хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах хугацаа богино байна. Ийнхүү хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хугацаа бага байх нь судалгааны чанар болон судлаачийн бүтээмжид сөргөөр нөлөөлдөг.

4.3. Монгол Улсад хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан мэдээний уялдаагүй, зөрүүтэй болон хаалттай байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд саад учруулж байна.

4.4. Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний дараагаар хуулийн төслийг боловсруулахаар заасан. Гэвч практикт энэхүү үе шатны дараалал алдах тохиолдол цөөнгүй бөгөөд хуулийн төслийн боловсруулсны дараагаар тэрхүү төсөлд нийцүүлэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хандлага давамгайлж байна. Энэ нь хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ач холбогдлыг бууруулах эрсдэлтэй төдийгүй хуулиас гарч байгаа

хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг буруу илрүүлэх сул талтай.

V. Зөвлөмж

Хууль тогтоомжид хэрэгжилтийг үр дагаварт үнэлгээ хийхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах зөвлөмжийг боловсруулж байна. Үүнд:

1. Хууль тогтоомжийн судалгаа, ялангуяа хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх чиглэлийн дагнасан сургалтыг эрх зүйн хичээлийн хөтөлбөрт оруулах, төрийн албан хаагч болон хуульч нарыг бэлтгэх чиглэлийн сургалтыг зохион байгуулах хэрэгцээ, шаардлага бий болсон. Энэхүү сургалтыг тогтмол зохион байгуулах нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийж буй үнэлгээний арга зүй, чанарыг дээшлүүлэх, мэргэшсэн судлаачдыг хомсдолыг арилгах ач холбогдолтой.

2. Хууль тогтоомжийн тухай хуулиар хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд шаардагдах хугацааг тодорхойлох нь зүйтэй. Энэ нь хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний чанарыг дээшлүүлнэ.

3. Төрийн байгууллагын зүгээс өөрсдийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх, тайлан дүн мэдээг судалгааны эргэлтэд ашиглах байдлаар байршуулах, нээлттэй болгох тогтмол, шинэчлэх хүрээнд анхаарах шаардлагатай.

4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-8.1.9-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатыг баримтлаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох замаар хуулийн төсөл боловсруулсны дараа хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж буй байдлыг өөрчлөх нь шаардлагатай.

[Ном зүй]

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №1, 1992 он.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2001, №45, 2001 он.

Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015, №25, 2015 он.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Улаанбаатар, 2017.05.12; 2023.05.04; 2024.05.16; 2025.06.27. <https://legalinfo.mn> .

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012, №14, 2012 он

Монгол Улсын Их Хурал. 2012 оны 37 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын Засгийн газрын 2012–2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр. Улаанбаатар, 2012. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=205591&showType=1>, 2012 .

Монгол Улсын Засгийн газар. Тогтоол №59. Аргачлал баглах тухай. Улаанбаатар, 2016. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11993> , 2016.

Монгол Улсын Засгийн газар. 59 дүгээр тогтоолын хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. Улаанбаатар, 2016. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338> , 2016.

Хууль зүй, дотоод хэргийн яам; Германы хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ). Хууль тогтоомжийн тухай хууль: аргачлал, гарын авлага. Улаанбаатар, 2016.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн хувийн хэрэг. Улаанбаатар, 2001.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал. Улаанбаатар, 2015.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дэлгэрэнгүй тэмдэглэл. Улаанбаатар, 2015.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл. Улаанбаатар, 2015.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар. Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны тэмдэглэл. Улаанбаатар, 2015.

Монголын Хуульчдын холбоо. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. Улаанбаатар, 2013. <https://www.mglbar.mn>, 2013 он.

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль. Үндсэн мэргэжлийн сургалтын төлөвлөгөө. Улаанбаатар, 2016. <https://law.num.edu.mn>, 2016 он.

Хууль зүйн үндэсний хүрээлэн. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэлийн төлөвлөгөө. Улаанбаатар, 2025 он.

Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Хууль тогтоомжийн судалгааны аргачлалын сургагч багш бэлтгэх сургалт” эхэллээ. <https://nli.gov.mn>, 2026 он.

Монгол Улсын Их Сургууль. “Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл” зэргийн бус сургалтын гэрчилгээ гардууллаа, <https://news.num.edu.mn/?p=113410>, 2026 он.

Монголын Хуульчдын холбоо. “Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт эхэллээ.” <https://www.mglbar.mn/a/5466> , 2026 он.

Үндэсний судалгааны нэгдсэн платформ. <https://sudalгаа.gov.mn> 2026 он.

[Abstract]

Legal Regulation for Conducting Ex-Post Evaluation of the Implementation Outcomes of Legislation: Challenges and Solutions

Khatansaikhan Ravdandorj

Master of Laws (LL.M.)

Senior Research Fellow at the National Legal Institute

Ulaanbaatar, Mongolia

Khaliun Sarantuya

Bachelor of Laws (LL.B.)

Lawyer and Attorney at Batbayar & Partners LLP

Ulaanbaatar, Mongolia

Until 2015, the process of initiating, drafting, and submitting legislation to the State Great Khural was carried out intensively. During this period, the laws adopted and enforced by the State Great Khural tended to be developed primarily in response to the socio-economic needs of the time rather than being based on systematic planning and thorough research. This issue was specifically noted in the concept paper of the revised draft Law on Procedures for Drafting, Submitting, and Implementing Legislation. Furthermore, the Government Action Plan of Mongolia for 2012–2016, approved by Resolution No. 37 of the State Great Khural in 2012, included a provision to “adopt the Law on Legislation and assess the necessity and implementation of laws.” Consequently, beginning with the Law on Legislation (2015), Mongolia established a legal framework for evaluating the implementation of legislation. This article examines the legal framework for conducting legislative impact assessments and the challenges associated with it. In doing so, it identifies the difficulties encountered in implementing the mandate of the National Legal Institute to regularly evaluate the implementation of legislation governing general relations in the fields of criminal, civil, administrative, and petty offense law, and proposes specific recommendations aimed at addressing these issues.

[Keywords]

Legislation, Ex-post Legislative Impact Assessment, Implementation Challenges, National Legal Institute, Human Resources, Professional Capacity, Training.